

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 01 сарын 25 өдөр

Hyraap 01

Улаанбаатар хс

Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн ерөнхий бүдүүвч, орон тооны дээд хязгаарыг батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг үндэслэн. Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

- 1. Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын ерөнхий бүтцийг хавсралтаар баталсугай.
- 2.Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг 389 хүнээр тогтоосугай.
- 3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны 01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



Ч.ХҮРЭЛБААТАР

## ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ БҮТЭЦ, ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭ

Тогтолцооны статус	Байгууллагын нэр	Эрхлэх асуудлын хүрээ
Төрийн аудитын дээд байгууллага	Үндэсний аудитын газар	<ul> <li>Төрийн аудитын байгууллагыг шаардагдах нөөц болон мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах</li> <li>Төрийн аудитын байгууллагын хөгжлийн бодлого, стратеги, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх</li> <li>Төрийн аудитын үйл ажиллагаанд мөрдөх стандартыг боловсруулж, хэрэгжилтий хангуулах</li> <li>Төрийн аудитын арга зүй, аргачлал, заавар</li> </ul>
		журмыг баталж, мөрдүүлэх  • Аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөө
		<ul> <li>боловсруулж, хэрэгжилтийг хангуулах</li> <li>Төрийн аудитын байгууллагын хүний нөөцийг удирдлагыг хэрэгжүүлэх</li> <li>Төрийн аудитын үйл ажиллагааны чанарыг хяналт, баталгаажуулалтыг хэрэгжүүлэх</li> <li>Төрийн аудитын үйл ажиллагаанд мэдээллийг</li> </ul>
		технологи, шилдэг туршлага, шийдлий нэвтрүүлэх  Терийн аудитын байгууллагын гадаа
		харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх  Терийн аудитын байгууллагын санхүүгий нөөцийг удирдах, төсвийг боловсруулж батлуулах, захиран зарцуулж, тайлагнах  Терийн аудитын төрөлжсөн болон оро
A		нутгийн байгууллагад захиргааны болон хуул эрх зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх  • Төрийн аудитын үйл ажиллагааны талаар оло нийтийг мэдээллээр хангах
Төрийн аудитын төрөлжсөн байгууллага	Гүйцэтгэлийн аудитын газар	<ul> <li>Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийх</li> <li>Төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, төрий болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд аудит хийх</li> <li>Олон улсын байгууллага, гадаад орны санхүүжилтээр ажилладаг байгууллага, төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд тэдний хүсэлтээр аудит хийх</li> </ul>

	Нийцлийн аудитын газар Санхүүгийн аудитын газар	<ul> <li>Засгийн газрын тусгай зориулалтын сан, тесвеес олгосон санхүүгийн дэмжлэг, эргэж телегдөх нехцелеер ашиглуулж байгаа тесвийн херөнге болон олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар,байгууллага, иргэдээс Монгол Улсын Засгийн газар,тесвийн байгууллагад олгосон зээл тусламж, хандивын ашиглалт, зарцуулалт, үр дүнд аудит хийх</li> <li>Улсын тесвийн херөнгө оруулалт, түүний үр дүнд аудит хийх</li> <li>Монгол Улсын жилийн тесвийн теселд аудит хийх</li> <li>Аудитын явцад илэрсэн телбер, зерчилд акт тавих, албан шаардлага, санал өгөх</li> <li>Терийн өмчийн ашиглалт, зарцуулалтад аудит хийх</li> <li>Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн улс терийн нам, намуудын сонгуулийн эвслийн сонгуулийн мерийн хетелберт дүгнэлт гаргах</li> <li>Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонгуулийн мерийн хетелберт дүгнэлт гаргах</li> <li>Засгийн газрын баталгаа, зээл, санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд аудит хийх</li> <li>Тесвийн хөрөнгөөр болон тесвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих теслийн техник, эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийх</li> <li>Улсын нэгдсэн тесвийн гүйцэтгэл, Засгийн газрын жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан, тесвийн байгууллагуудын болон</li> </ul>
		төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийх  Хууль тогтоомжид заасан бусад асуудлын хүрээнд аудит хийх
Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага	Нийслэл дэх төрийн аудитын салбар байгууллага	<ul> <li>Орон нутгийн захиргааны болон төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн тайланд аудит хийх</li> <li>Орон нутгийн төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд аудит хийх</li> <li>Орон нутгийн төсвийн жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийх</li> </ul>
	Аймаг дахь төрийн аудитын салбар байгууллага	<ul> <li>Орон нутгийн төсвийн төсөлд санал боловсруулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах</li> <li>Бусад</li> </ul>